



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/092/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор С.Отгонхорлоо
Утас:261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитор Г.Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: Oyuntuguldurg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

2025.03.14 № 1025

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг өртгийн объектоор тооцохоор тодорхойлсон боловч бусад хамаарал бүхий бүтцийг тодорхой болгоогүйгээс өртгийн төвд хуримтлуулан бүртгэх зардал тодорхойгүй;
- Тайланд онд 16 харилцагчтай 263.9 сая төгрөгийн авлагын, 6 харилцагчтай 3.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Хөгжлийн банкны зээлийн урт хугацаат зээлийн эргэн төлөлтийг 2024 оны 06 дугаар сараас хойш хуваарийн дагуу төлөөгүйгээс тайлант оны эцэст 10,176.7 сая төгрөгийн үндсэн төлбөр, 9,700.4 сая төгрөгийн хүүгийн төлбөр, нийт 19,877.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 4.4.3-т "Дуусаагүй үйлдвэрлэл "Нэгж бүр үйлдвэрлэлийн зардлын дансаар өөрт гарсан зардлыг хуримтлуулахаас гадна үйлчилгээний нэгжүүдийн зардлаас үйлдвэрлэлийн нэгжүүдэд хуваарилах зарчмаар бүтээгдэхүүний өртгийг иж бүрэн тооцно", 4.4-т "Өртгийн төв бүр зардал хуримтлуулан бүртгэх данстай байна. Үйлдвэрлэлийн нэгж бүрээр нээсэн зардлын дансанд үйлчилгээний нэгжүүдийн зардал хуваарилагдах зарчмаар бүтээгдэхүүний өртгийг тооцоолно", Монгол Улсын Хөгжлийн банкттай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-д "зээлдэгч эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрийг төлнө", 5.2-т "зээлийн төлбөрийг төлөөгүй эсхүл дутуу төлсөн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү, үндсэн хүү, үндсэн зээл гэсэн дарааллаар төлнө", Монгол Улсын Иргэний тухай хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-д "Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн ба зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мега төслийн хүрээнд зуух 9-ийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх ажлыг 108.2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Тус шинэ зуухыг барьснаар өвлийн их ачааллын үеийн уурын дутагдлыг нөхөж, станц суурилагдсан хүчин чадлаар ажиллаж, Оросын Холбооны Улсаас авах цахилгаан эрчим хүчний хэмжээг 52 МВт/ц-аар бууруулах боломжтой болно.

Эрчим хүчний яамнаас эрчим хүчний шинэчлэлийн хүрээнд 200.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 8 төсөл хөтөлбөрт 159.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Зуух 5-8-ын хяналт удирдлагын системийн шинэчлэлийн төхөөрөмжийг Yokogawa компани 2020 оноос хойш үйлдвэрлээгүй, 2025 оноос эхлэн завсар үйлчилгээг зогсоохыг мэдэгдсэн байна. Тайлант онд станцын үндсэн тоноглол болох зуухнуудыг нэгэн зэрэг аваараар зогсоож, Монгол Улсын эрчим хүчний системийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл үүссэн тул зуух 5-8-ын шинэчлэл, засварын 6,069.6 сая төгрөгийн ажлыг хийсэн.

Зуух 1-4-ийн тоосон системийн хийн трактыг шинэчлэх ажилд 1,099.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 16, 632, 636 тогтоолуудаар орсон өөрчлөлтүүдийг мөрдөж ажилласан, мөн 748 дугаар тогтоолоор 2024 оны 12 дугаар сард энергийн 1 кВт/ц-ын тарифыг 46.6 төгрөгөөс 66.39 төгрөг, чадлын тарифыг 15,658.2 сая төгрөгөөс 41,145.3 сая төгрөг болгон нэмэгдүүлснээр Диспетчерийн үндэсний төвийн борлуулсан цахилгаан эрчим хүчний орлого 35,269.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

The image shows a handwritten signature in black ink over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text: "МОНГОЛ" (MONGOLIA) at the top, "ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА" (STATE AUDIT AGENCY) in the middle, and "УЛААНБААТАР" (ULANBAATAR) at the bottom. To the right of the stamp, the name "Д.ЗАГДЖАВ" (D. ZAGDZHAB) is printed in black capital letters.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,066,309,287.89	4,189,565,434.99
1.1.2	Дансны авлага	21,556,224,937.79	33,370,352,356.13
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	1,549,611,200.22
1.1.4	Бусад авлага	492,789,215.60	380,914,577.99
1.1.6	Бараа материал	29,642,429,553.28	37,027,359,079.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	6,358,272,362.49	7,173,136,829.04
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	72,116,025,357.05	83,690,939,478.10
1.2	Эргэлийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	843,456,526,874.37	817,222,074,036.93
1.2.2	Биет бус хөрөнгө	77,047,166,798.14	77,370,864,709.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,092,304,461.02	2,071,355,367.71
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	921,595,998,133.53	896,664,294,113.64
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	993,712,023,490.58	980,355,233,591.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,885,660,522.51	2,098,424,629.12
2.1.1.2	Цалингийн өглөг	6,801,086,633.17	9,208,830,113.58
2.1.1.3	Татварын өр	5,581,471,921.31	1,998,104,680.53
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	24,988,587.40
2.1.1.5	Богино хугацаат зээл	17,636,287,204.27	52,577,886,635.22
2.1.1.6	Хүүний өглөг	791,402,599.39	11,293,112,477.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,000,301,544.91	1,037,097,801.78
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	4,087,902,688.64	7,339,214,943.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,465,850,480.61	1,867,326,144.66
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	39,249,963,594.81	87,444,986,012.33
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	390,116,249,809.56	332,925,785,905.13
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	13,018,062,058.50	15,323,810,723.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	7,305,387,027.86	1,673,209,875.52
2.1.2.5	Хойшлогдсон орлого	17,012,543,709.65	16,086,990,204.77
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	427,452,242,605.57	366,009,796,708.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	466,702,206,200.38	453,454,782,720.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч а) төрийн	227,071,740,030.34	228,213,686,843.34
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	257,661,148,835.64	257,138,427,145.56
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	78,008,219,977.00	76,866,273,164.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-35,731,291,552.78	-35,317,936,281.91
2.3.11	Эздийн өмчийн дүн	527,009,817,290.20	526,900,450,870.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	993,712,023,490.58	980,355,233,591.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	430,276,925,672.40	453,737,597,567.53
2	Борлуулалтын өртөг	408,996,784,264.99	482,607,511,218.74
3	Нийт ашиг /алдагдал/	21,280,141,407.41	-28,869,913,651.21
4	Түрээсийн орлого	192,278,595.39	223,754,503.08
5	Хүүний орлого	148,770,121.60	127,577,647.47
8	Бусад орлого	5,639,898,047.28	36,812,719,289.23
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,705,543,280.61	2,843,715,685.72
10	Ерөнхий удирдлагын зардал	6,507,216,926.76	8,046,711,566.94
12	Бусад зардал	10,128,440,926.15	14,271,606,298.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-2,286,387,018.72	17,182,392,648.55
17	Бусад ашиг /алдагдал/	43,584,803.87	2,474,345.91
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	5,677,084,823.31	316,971,231.60
19	Орлогын татварын зардал	4,515,174,976.90	1,873,806,122.95
20	Татварын дараах ашиг /алдагдал/	1,161,909,846.41	-1,556,834,891.35
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,161,909,846.41	-1,556,834,891.35

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	-36,186,439,590.67	526,554,669,252.31
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-706,761,808.52	-706,761,808.52
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	1,161,909,846.41	1,161,909,846.41
9	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	-35,731,291,552.78	527,009,817,290.20
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,970,190,162.22	1,970,190,162.22
11	Залруулсан үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	-33,761,101,390.56	528,980,007,452.42
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	-1,556,834,891.35	-1,556,834,891.35
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,141,946,813.00	1,906,808,209.99	-1,141,946,813.00	-	1,906,808,209.99
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-2,429,529,900.07	-	-	-2,429,529,900.07
17	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	228,213,686,843.34	257,138,427,145.56	76,866,273,164.00	-35,317,936,281.91	526,900,450,870.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн /+/ Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого Татаас, санхүүжилтийн орлого Бусад мөнгөн орлого	406,770,690,205.81 404,445,333,734.55 - 2,325,356,471.26	456,437,843,816.44 425,357,757,977.37 28,041,030,000.00 3,039,055,839.07
1.2	Мөнгөн зарлагын дүн /-/ Ажиллагчдад төлсөн Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн Бараа материал худалдан авахад Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн Хүүний төлбөрт төлсөн Татварын байгууллагад төлсөн Даатгалын төлбөрт төлсөн Бусад мөнгөн зарлага	376,335,551,600.69 50,475,918,060.46 16,606,078,005.64 184,700,000,000.00 55,802,060,763.25 12,662,759,909.25 15,017,202,147.09 65,469,430.14 41,006,063,284.86	463,468,888,078.30 74,267,882,393.00 19,937,000,000.00 194,875,062,732.24 72,423,437,957.52 27,838,704,509.24 34,052,529,195.97 38,279,716.23 40,035,991,574.10
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	30,435,138,605.12	-7,031,044,261.86
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн /+/ Хүлээн авсан хүүний орлого	148,770,121.60 148,770,121.60	127,577,647.47 127,577,647.47
2.2	Мөнгөн зарлагын дүн /-/ Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,092,808,816.17 2,092,808,816.17	4,857,086,254.51 4,857,086,254.51
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,944,038,694.57	-4,729,508,607.04
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн /+/ Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00 -	18,000,000,000.00 18,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн /-/ Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө Төлсөн ногдол ашиг	20,054,746,454.98 20,054,746,454.98 -	16,116,190,984.64 16,000,000,000.00 116,190,984.64
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,054,746,454.98	1,883,809,015.36
3.4	Валютын ханшийн зөрүү	-258,847,098.13	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,177,506,357.44	-9,876,743,853.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,888,802,930.45	14,066,309,287.89
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,066,309,287.89	4,189,565,434.99

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Боловсруулах эрчим хүч	ЦЭХ	сая кВт.ц	4,871.4	4,971.8	4,985.9	14.0
		ДЭХ	мян.Гкал	4,636.9	4,814.8	4,733.8	-81.0
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	11.12	11.37	11.03	-0.34
		биетээр	сая кВт.ц	541.9	560.4	549.7	-10.7
	Түгээх эрчим хүч	ЦЭХ	сая кВт.ц	4,329.5	4,411.5	4,436.1	24.7
ДЭХ		мян.Гкал	4,636.9	4,814.8	4,733.8	-81.0	
2	Нийт орлого		сая төг	436,301.4	430,943.6	508,086.5	77,142.9
	Үйл ажиллагааны орлого татаас		сая төг	430,276.9	425,786.2	453,737.6	27,951.4
	Үйл ажиллагааны бус орлого		сая төг	0.0	0.0	25,491.8	25,491.8
			сая төг	6,024.5	5,157.4	28,857.1	23,699.7
3	Нийт зардал		сая төг	430,624.3	482,688.7	507,769.6	25,080.9
	Үндсэн үйл ажиллагааны зардал		сая төг	423,678.4	477,977.2	503,910.3	25,933.1
	Үүнээс:	түлш	сая төг	218,078.6	227,165.4	238,189.4	11,024.0
		элэгдэл	сая төг	65,694.5	65,525.3	71,439.5	5,914.2
		бусад тогтмол	сая төг	139,905.3	185,286.5	194,281.4	8,994.9
Үйл ажиллагааны бус зардал		сая төг	6,945.9	4,711.5	3,859.3	-852.2	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	5,677.1	-51,745.0	316.9	52,062.0
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	1,161.9	-51,745.0	-1,556.8	50,188.1
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	0.98	1.12	1.11	-0.01
7	Нийт авлага		сая төг	22,049.0	14,400.0	35,300.9	20,900.9
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг	21,556.2	13,690.0	33,370.4	19,680.4
		Бусад	сая төг	492.8	710.0	1,930.5	1,220.5
8	Нийт өглөг		сая төг	466,702.2	401,906.5	453,454.8	51,548.3
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг	39,250.0	107,421.3	87,445.0	-19,976.3
		Урт хугацаат өр төлбөр	сая төг	427,452.2	294,485.2	366,009.8	71,524.5
9	Нийт ажиллагсад		тоо	1,487.0	1,487.0	1,486.0	-1.0
10	Нийт цалингийн сан		сая төг	62,813.7	81,060.90	81,060.90	0.00
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	271.9	275.0	273.4	-1.6
		ДЭХ	кг/Гкал	171.7	171.6	171.5	-0.1
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	34,031.5	52,349.1	43,732.6	-8,705.2
	Их засвар		сая төг	32,582.6	41,347.4	33,232.9	-8,114.9
	ТЗБАХ		сая төг	0.0	7,415.4	7,733.1	317.7
	ХО		сая төг	1,448.9	3,586.3	2,766.6	-819.7

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 892.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 10 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-тай 2022.03.21-ний өдөр 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалтууд авч, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн боловч 1.7 сая төгрөгийн үлдэгдлийг тайлант онд зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	1	1,738.7			1	1,738.7	1	1,738.7				
Yokogawa Engineering Asia Pte.Ltd компанитай Г/2020-12 дугаар гэрээг байгуулж, 2020.11.12-ны өдөр 52,280 ам.доллар буюу 149.0 сая төгрөгийг шилжүүлж, 2021 онд 143.2 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авсан боловч валютын ханшийн зөрүүнээс үүссэн 19.3 сая төгрөгийг бараа материалын өртөгт шингээгээгүй, урьдчилгаа дансанд үлдэгдэлтэй.	1	19,300.7			1	19,300.7	1	19,300.7				
Гадаад валютаар илэрхийлсэн Anneng power station equipment group-ийн өглөгийн 2024.01.31-ний өдрийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэлийн бодит ашиг 1.6 сая төгрөг, Ёкогава компанийн урьдчилж төлсөн төлбөрт 2024.05.09-нөөр тооцсон гадаад валютын ханшийн бодит бус олз 1.1 сая төгрөг, Ёкогава компанид 2024.05.09-нд төлсөн төлбөрт тооцсон гадаад валютын ханшийн бодит алдагдал 0.1 сая төгрөг, Ёкогава компанийн урьдчилж төлсөн төлбөрт 2024.05.31-нээр тооцсон гадаад валютын ханшийн бодит бус олз дансны дебетэд 0.5 сая төгрөг, нийт 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.	1	3,299.8			1	3,299.8	1	3,299.8				
Авлага, өглөгийн дэлгэрэнгүй тайланд ажилтнуудад олгосон буцалтгүй тусламжийн зардлыг харилцагчийн нэр зөрүүтэй бүртгэн хасах дүнгээр илэрхийлж, санхүүгийн тайланг 3.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	3,014.9			1	3,014.9	1	3,014.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар НӨАТ-ын тайланг бэлтгэхдээ НӨАТ ногдох орлогыг 273.2 сая төгрөг, НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогыг 134.9 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлж, НӨАТ-ыг 27.3 сая төгрөгөөр дутуу ногдуулж тайлагнасан.	1	273,168.8			1	273,168.8	1	273,168.8				
Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн 2023 оны 02 дугаар тогтоолоор Татварын улсын байцаагчийн 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн НА2122000016 дугаар нөхөн ногдуулалтын актаар тогтоосон 166.5 сая төгрөгийн нөхөн татвар, 66.6 сая төгрөгийн торгууль, 32.8 сая төгрөгийн алданги, нийт 266.0 сая төгрөгийг бууруулсан шийдвэр гарсан боловч татварын газрын системийн алдаанаас шалтгаалсан үндэслэлээр татварын дэнчинд төлсөн 266.0 сая төгрөгийг ХХОАТ-ын өглөгөөс хасалт хийлгээгүй урьдчилгаа дансанд бүртгэлтэй, асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй.	1	266,052.5			1	266,052.5	1	266,052.5				
ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар 2018-2019 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 68 ажилчин, албан хаагчдад олгосон тэтгэмжээс 2018 онд 129.0 сая, 2019 онд 22.2 сая төгрөгийн ХХОАТ суутгаж, тайлагнан нийт 151.2 сая төгрөгийг татварын орлогын дансанд шилжүүлсэн байна. Тус суутгал нь хуульд нийцээгүйг шүүхээс тогтоосон тул шийдвэрүүдийн дагуу ажилчдад мөнгийг буцаан олгосон боловч татварт шилжүүлсэн мөнгөний асуудлыг Татварын ерөнхий газарт хандаж эцэслэн шийдвэрлүүлээгүй хөөн хэлэлцэх хугацаа дуусгасан ба буцааж авах үндэслэлгүй болсон 151.2 сая төгрөг урьдчилгаа дансанд бүртгэлтэй.	1	151,234.5			1	151,234.5	1	151,234.5				
Хувь хүний орлогын албан татварт 2022 оны илүү төлөлтөөс үлдсэн, татварын газартай тооцоо нийлж баталгаажуулаагүй 160.4 сая төгрөгийн үлдэгдэл урьдчилгаа дансанд бүртгэлтэй.	1	160,489.4			1	160,489.4	1	160,489.4				
Өмнөх онуудад үүссэн тооцоо нийлж өглөгийг барагдуулаагүй, бүртгэлд тайланд зөрүүтэй тусгасан залруулаагүй үлдэгдлүүд байна. Тухайлбал: Тэтгэвэр, тэтгэмжийн өглөг Бямбадоржид 2.1 сая, илүү суутгасан ХХОАТ 2.2 сая төгрөг байна.	1	4,364.6			1	4,364.6	1	4,364.6				
ТБС арвижих ХХК-д 2022.11.23-нд 9.8 сая төгрөгийн бараа материалын урьдчилгаа шилжүүлсэн боловч 2024.11.30-ны өдрийн байдлаар барааг хүлээж аваагүй.	1	9,800.0	1	9,800.0			1	9,800.0				
Дүн	10	892,463.9	1	9,800.0	9	882,663.9	10	892,463.9	-	-	-	-

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2. Аудитаар нийт 21,132.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэх 12.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, таслан зогсоох 20,881.5 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 60.3 сая төгрөгийн 16 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Борлуулалтын орлогоос түүвэрт хамрагдсан хаалтын бичилт хийж байгаа ажил гүйлгээний /Сангийн яамны баталгаажуулсан мэдэгдэл, УБТЗ ХНН, Багануур ТӨХК, Шивээ-Овоогийн уурхай ТӨХК-тай тооцоо нийлсэн актууд, цахилгаан, дулаан, уур, усны техникийн нөхцөл олгох, үйлчилгээний орлогын гүйлгээ ... гэх мэт/ анхан шатны баримтыг хавсаргаагүй байна. /ДҮТ, УБЦС/	1	-						1	-				
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"-т тогтоосон м2 талбайн түрээсийн доод жишиг үнээс 5500 төгрөгөөр буюу сард 1,100,000.00 төгрөгөөр, нийт 12.2 сая төгрөгөөр бага үнээр түрээсийн гэрээг байгуулсан байна.	1	12,200.0	1	12,200.0									
Дараа тайлангаарх 7.7 сая төгрөгийн авлагыг хоорондын тооцоогоор хааж бүртгэсэн байна.	1	7,770.7						1	7,770.7				
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 169, ТУЗ-ийн 2024 оны 16 тогтоолуудаар өөрийн орлого болох шийдвэртэй 628.6 сая төгрөгийн баталгаат хугацааны барьцааны өглөг, цахилгаан, дулаан, уур хэрэглэгчдийн тогтмол гэрээтэй 117 харилцагчдаас авах 705.3 сая төгрөгийн борлуулалтын авлагууд үүссэн, Диспичерийн үндэсний төв буюу нэг худалдан авагчаас авах авлага 11,734.9 сая төгрөгөөр тайлант онд нэмэгдсэн, 16 харилцагчтай 263.9 сая	1	266,896.4			1	266,896.4							

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

төгрөгийн авлага, 6 харилцагчийн 3.0 сая төгрөгийн өглөг, нийт 266.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.												
Найдваргүй авлагын нөөцийн хэмжээг 2021-2024 оны авлагатай харьцуулахад 2021 онд 4.6 хувь, 2022 онд 4.7 хувь, 2023 онд 5.9 хувь, 2024 онд 1.8 хувийг тус тус эзэлж байна. Найдваргүй авлагын нөөцийг 2021 онд 147.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2022 онд 607.4 сая төгрөгөөр, 2023 онд 194.8 сая төгрөгөөр, 2024 онд 79.2 сая төгрөгөөр тус тус бууруулж өөрчлөлт оруулсан нь авлагын насжилтын мөчлөгийн уртад тохирсон хувь хэмжээг тогтоогоогүй, НББББ-т нөөц байгуулах тусгайлсан хувь хэмжээг заагаагүй, тууштай байдлыг баримталж ажиллаагүй байна. Мөн бараа материалын хасагдуулсны насжилтад тохирсон тусгайлсан хувийг НББББ-т тусгаагүй тул найдваргүй авлагын нөөц, бараа материалын хасагдуулгыг тооцоо, судалгаа, үнэлгээ, дүгнэлт зэрэгт үндэслэн салбарын онцлогт тохирсон тусгай хувь тогтоон, НББББ-т өөрчлөлт оруулж, тууштай мөрдөх шаардлагатай байна.	1		-				1		-			
Аюулгүйн нөөцөд байвал зохих 132 нэр төрлийн 60,934.09 нэгж бараа материалаас тайлант оны эцэст 60 нэр төрлийн 51,243.45 нэгж бараа материал байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд аюулгүйн нөөц дүүргэх төлөвлөгөө тусгагдаагүй тул нөөцийг нэмэгдүүлээгүй байна.	1		-				1		-			
Урьдчилж орсон орлого дансны үлдэгдлээс 34.2 сая төгрөгийг тайлант оны борлуулалтын орлого болон НӨАТ-ын өглөгөөр бүртгээгүй, авлагын данс руу хааж бичилт хийсэн.	1		34,236.0				1		34,236.0			
Тайлант онд худалдан авагчаас харилцах дансанд орсон бараа ажил үйлчилгээний илүү төлөлтийг урьдчилж орсон орлого данснаас харилцах данс руу бүртгээгүй, авлагын дансны дүнг нэмэгдүүлж бүртгэсэн.	1		-				1		-			
Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 1 болон түүнээс дээш жилийн насжилттай 11.3 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1		11,320.9				1		11,320.9			

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2012.05.17-ны өдрийн А/344 захирамжаар ДЦС-4 ТӨХК-д "Амины орон сууц хотхон" зориулалтаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсэн 20000м2 газрын эзэмших эрхийн хугацааг сунгах зорилгоор 2012 онд 64.0 сая төгрөгийн дэнчинг Нийслэлийн газрын албанд шилжүүлсэн боловч хугацааг сунгаагүй, асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.	1	64,000.0			1	64,000.0						
Тэтгэвэр тэтгэмжийн өглөгийн харьцах дансыг дэлгэрэнгүй болон товчилж бичсэнээс өглөгийн үлдэгдэлтэй сөрөг үлдэгдэлтэй илэрхийлсэн. Хамтын гэрээний дагуу шагнал урамшууллын өглөгийг данс бүртгэлд үнэн зөв харьцуулж бүртгээгүйгээс данс сөрөг үлдэгдэлтэй байна.	1	-			1	-						
Гэрээний дагуу засварын ажлын баталгаат хугацааны барьцаанд суутгасан 3 жилээс дээш насжилттай барьцааны 7.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг гүйцэтгэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	7,001.3			1	7,001.3						
Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 7 жилийн хугацаатай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар гэрээгээр 70.6 сая евро буюу 260,093.9 сая төгрөгийн урт хугацаат зээл авсан байна. Тус зээлийн эргэн төлөлтийг 2024 оны 06 дугаар сараас эхлэн хуваарийн дагуу төлөөгүйгээс тайлант оны эцэст 10,176.7 сая төгрөгийн үндсэн төлбөр, 9,700.4 сая төгрөгийн хүүгийн төлбөр, нийт 19,877.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй байна.	1	19,877,125.7			1	19,877,125.7						
Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, зуухны шинэчлэл, турбины хяналт удирдлага, зуухны үлээлгийн аппарат, бул таваг шинэчлэх зорилгоор Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлийн MON-P6, ЭХҮА-II, MON-P10 дугаартай 3 гэрээний эргэн төлөлтийг гэрээнд заасан хуваариас өмнө 6 удаагийн давтамжтайгаар нийт 2,771.3 сая төгрөгийг илүү төлсөн нь мөнгөн урсгалын төлөвлөлт алдагдаж, жилийн турш мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлсэн байна.	1	-			1	-						

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

<p>Ажилчдын тэтгэмжийг бүртгэлийн хувьд урт, богино хугацаат өр төлбөр лүү ангилдаг боловч хөрөнгө талд богино хугацаат руу шилжүүлсэн ажилтны тэтгэмжийг хуримтлуулсан тусдаа харилцах данс байхгүй байна. Ажилчдын тэтгэмжийн нэрлэсэн үнэ, нөөц актуар тооцооны өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүнгийн зөрүүнд дүн шинжилгээ хийхэд 783.7 сая төгрөг байгаа нь актуар тооцооллыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тус актуар тооцоололд тухайн ажилтны ажлын нөхцөл өөрчлөгдсөн шилжилт хөдөлгөөн гарсан тохиолдол, ажлаас гарах магадлал, олон хүүхэдтэй ээж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байна.</p>	1	-				1	-		
<p>ТУЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн удирдлагын бүтэц зохион байгуулалтыг 20 нэгж, хэсэгтэй байхаар баталсан. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг өртгийн объектоор тооцохоор өртгийн 4 төв, үйлчилгээний 7 нэгжийг тодорхойлсон боловч бусад 9 нэгж, хэсгүүдийн хамаарал бүхий бүтцийг тодорхой болгоогүйгээс өртгийн төвд хуримтлуулан бүртгэх зардал тодорхойгүй, Үйлдвэрлэлийн өртгийг тооцохдоо гүйцэтгэх захирлын 2020 оны "Технологийн үе шатны аргаар өртөг тооцох аргачлал" хувилбар 1-т технологийн үе шатны аргаар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдэлд суурилсан өртөг тооцох аргаар тооцохоор тусгасан. 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаарх борлуулсан бүтээгдэхүүний өртөг 482,607.5 сая төгрөгийг задалж үзвэл 16 нэгжийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн бөгөөд үйлдвэрлэлийн 4 нэгжийн өртгийн төвд үйлчилгээний 12 нэгжийн зардлыг хуваарилж, бүртгээгүй байна.</p>	1	-				1	-		
<p>Тус байгууллага нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үе шаттайгаар тооцон хэрэгжүүлээгүй. Үүнд: 1. Дуусаагүй үйлдвэрлэлийг үйлдвэрлэлд зарцуулагдсан материал болон тайлант хугацаанд үйлдвэрлэж дууссан бүтээгдэхүүний өртгийн зөрүүгээр бүртгээгүй, үйлдэлд</p>	1	-				1	-		

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

<p>суурилсан өртөг тооцдоггүйгээс тус дансыг хөтлөөгүй, урьдчилж төлсөн зардал дансаар дамжуулан бүртгэсэн.</p> <p>2.Технологийн шат дамжлагын дагуу өртгийн төвүүдээс бий болсон техникийн ус, эргэлтийн ус, тэжээлийн ус, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, үйлдвэрийн уур, нэмэлт ус, дамжуулсан нүүрс, хурц уурын өртгийг тооцоогүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тайлан бэлтгээгүй.</p> <p>3.Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг борлуулалтын өртгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх үетэй зэрэгцүүлж харуулахаар заасан боловч Орлогын дэлгэрэнгүй тайланд зөвхөн 16 нэгжид хуримтлуулан бүртгэсэн зардлуудыг тайлагнасан байна.</p>												
<p>Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр, ажилчдын тэтгэмжийн нөөцтэй холбоотой түр зөрүүгийн тооцооллыг хийж бүртгэсэн боловч элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй байна.</p>	1		-			1		-				
<p>Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 12 ангиллын 950 нэр төрлийн 5,476.2 сая төгрөгийн хөрөнгийг сүүлийн 3-5 жилд дахин үнэлж бүртгээгүй, 4 ангиллын 30 нэр төрлийн 61.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг хөрөнгийг актлах хүсэлтийг өмч хамгаалах байнгын комиссын шийдвэрээр гаргасан, 12 ангиллын 920 нэр төрлийн тавилга, тоног төхөөрөмжийг 5,414.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй.</p>	1		-			1		-				
<p>Тайлант оны 6 дугаар сарын цаг бүртгэлийн машинд бүртгэгдсэн ирцийн мэдээллийг цагийн баланс руу тулган түүвэрлэн шалгахад 272 хүнтэй холбогдох 6793 цагийг гадуур ажлаар бүртгэсэн боловч ажлын бүртгэл тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, системд цахим хяналт болон бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Мөн хувийн шалтгаанаар чөлөө хүссэн 18 ажилтанд 205.4 цагийн чөлөө олгосон шийдвэрийг тушаалаар баримтжуулаагүй байна. "Астериск технологис" ХХК-тай</p>	1	178,783.8			1	178,783.8						

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлсэн ERP системийн ирцийн бүртгэлийн системээс хэлтэс, ажилтнаар, өдөр, сараар нэгтгэсэн мэдээлэл гаргах боломжгүй, ирцийн бүртгэлд мэдээлэл оруулж засварлаж оруулсан хүний нөөцийн ажилтанд нягтлан бодогч давхар хяналт хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй байна; Тайлант онд ажиллаагүй 9 ажилтныг ажилласнаар бүртгэн 157.0 сая төгрөгийн цалинг үндэслэлгүй олгож, байгууллагаас 21.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, нийт 178.8 сая төгрөгийн зардал гаргасан												
Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн цаг бүртгэлийн машинд бүртгэгдсэн цагийг цагийн баланс руу тулган түүвэрлэн шалгахад цагийн бүртгэлгүй 13 ажилтанд 532.4 сая төгрөгийн цалин олгосон.	1	-				1	-					
Тайлант хугацаанд байгуулсан Д/2024-211, Д/2024-332 дугаар гэрээний дагуу нийлүүлэх нийт 189.1 сая төгрөгийн бараа материалыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй, гэрээг эцэслэн дүгнээгүй байна	1	189,050.0			1	189,050.0						
Тайлант хугацаанд зохион байгуулсан "Редуктор" тендерт оролцсон Дээд тив ХХК-аас ирүүлсэн санхүүгийн чадавхыг нотолсон нотлох баримтад 102.0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой байгаа нь сүүлийн жилийн борлуулалтын орлого тендерийн бичиг баримтад тусгасан үнийн саналд хүрээгүй, санхүүгийн чадавхын шаардлагыг хангаагүй байхад тус компанийг сонгон шалгаруулсан байна.	1	101,996.3			1	101,996.3						

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Талх, нарийн боов", 20.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Тавилга /багц-2/", 34.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өргөст хэмх, улаан лооль", 65.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гурил", 77.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Дотоодод захиалах цутгуурын эд анги, 84.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сүү, сүүн бүтээгдэхүүн", 50.0 сая сая төгрөгийн "Мэдлэг тэмцээний хүрээнд туршлага судлах гадаад сургалт", нийт 351.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.	1	351,235.3			1	351,235.3						
Хуульд заасны дагуу нэмэлт гэрээг байгуулахгүйгээр 11.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үүнд: Ган бэлдэц худалдах, худалдан авах Д/2024-254 дугаартай гэрээний нийлүүлэгч захиалагчийн зөвшөөрлийн дагуу гэрээнд заасан 5 нэр төрлийн 4.4 сая төгрөгийн барааг дутуу нийлүүлж, нэмэлтээр 15.6 сая төгрөгийн бараа нийлүүлсэн	1	11,159.6			1	11,159.6						
Байгууллагын тодорхой хугацааны давтамжтай худалдан авдаг, байнгын хэрэгцээтэй, дотоодод үйлдвэрлэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, хөдөлмөр хамгааллын хувцас, төрөл бүрийн мах, будаа, төрөл бүрийн хүнсний ногоо, өндөг, лаазалсан хүнсний бүтээгдэхүүн, ажлын гутал, ажлын бээлий зэрэг "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолд тусгасан, цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр худалдан авах боломжтой бараа, ажил үйлчилгээний саналыг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, тендер шалгаруулалтын ерөнхий гэрээний аргыг хэрэглээгүй байна.	1	-			1	-						
Тайлант онд өдөр тутмын мэдээллийн агентлагтай Д/2024 дугаар гэрээг байгуулж, 20.0 сая төгрөгийн видео хийх ажлыг гүйцэтгүүлж, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	20,000.0			1	20,000.0						
Зөрчлийн дүн	27	21,132,776.0	1	12,200.0	10	21,060,247.1	16	60,328.9	-	-	-	-

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн асуудлаар нийт 14.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 10.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3.8 сая төгрөгийн 7 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.5-д заасныг үндэслэн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 469,313.6 мянган төгрөгийн 5 гүйлгээ, зарлагын 9,287.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн.	1	-			1	-
Шилэн дансны дүн	1	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тендерийн баримт бичигт тусгасан зарим бараа материалын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан захиалгыг ерөнхий инженерээр баталгаажуулаагүй, /Цэвэрлэгээний шингэн-аяга тавгийн 287 ш / 1577 ш-1290 ш/, зайлагч шингэн 89 ш /469-380/, угаалгын шингэн/89 ш /469-380/, Үнэлгээний хорооны 2024 оны 6 сарын 22-ны хурлын тэмдэглэлийн үнийн саналын үнэлгээнд төсөвт өртгийг 3.8 сая төгрөгөөр дутуу тусгасан.	1	3,870.1			1	3,870.1
Байгууллагын 2024 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан тендер шалгаруулалтын гэрээ болон гэрээ дүгнэсэн актыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад байршуулаагүй, ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.	1				1	-
Нийт ажилчдын эрүүл мэндийн хугацаат үзлэгийн ажил үйлчилгээ, үр дүнг тооцож гэрээг дүгнээгүй, Д/2024-370 дугаар гэрээний 8.2-т "Энэхүү гэрээний хэрэгжилтийг гэрээ дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан талуудын төлөөлөл бүхий бүрэлдэхүүн дүгнэж тэмдэглэл үйлдэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.	1				1	-
Тендерт оролцсон оролцогчдод тендерт шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлэхдээ гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнийг мэдэгдээгүй байна. Тухайлбал, "Ремень наалтын ком плитка б-1400", "Дотоодод захиалах цутгуурын эд анги"	1				1	-
Мэдлэг тэмцээний хүрээнд туршлага судлах гадаад сургалтын тендерийг зохион байгуулахдаа хараат бус гишүүнгүйгээр үнэлгээний хороог байгуулсан. Хамтран ажиллах гэрээний хавсралтын 1 дэх хэсэгт "Сургалтын хөтөлбөр" гэж заасан боловч гэрээнд хавсаргаагүй, сургалтын төсвийг батлуулаагүй, сургалтад явсан эсэхийг нотлох боломжгүй байна.	1				1	-
Тендерийн бичиг баримт болон холбогдох баримт бичгүүдэд зөрүүтэй мэдээлэл агуулсан байна. 1.Үнэлгээний хорооны хурлын шийдвэрт шалгарсан компанийн нэрийг "Экосмарт Солюшн" ХХК гэж бичсэн байхад Үнэлгээний хорооны зөвлөмжид Интерсайнс ХХК гэж бичсэн. /Утааны хийн анализаторын сэлбэг/ 2.Төрөл бүрийн паранит нийлүүлэх гэрээ дүгнэсэн актын хавсралтад 1.6 сая төгрөгийн паронит /ПМБ б=1.0/ ийг оруулаагүй	1				1	-
	нийт	дүнг	зөрүүтэй	тусгасан.		

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3. Тендерийн баримт бичигт бараа нийлүүлэх хугацааг 2043 оны 06 сарын 25 гэж алдаатай бичсэн; /Бага оврын микроавтобус/						
Тендерийн бичиг баримтын боловсруулалттай холбоотой дараах нийтлэг зөрчил байна. 1. Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөлийг тодорхой заагаагүй сонголтыг нээлттэй оруулсан; 2. Архивын баримтад үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификатын хуулбарыг хавсаргаагүй, баримт бичгийн бүрдэл дутуу, баримтын нэр төрөл, дугаарлалт байхгүй, бүртгэл хөтлөлт, хадгалалтад тавих хяналт сул байна; 3. Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр, худалдан авах ажиллагааны үе шатанд гаргаагүй; 4. Худалдан авах бараа материалын захиалгыг үндэслэлгүй тооцсоноос агуулахын үлдэгдэлтэйгээс шалтгаалан гэрээний дагуу зарим бараа материал нийлүүлэгдээгүй; 5. Сүлжээний төхөөрөмжийн сэлбэг материал болон хувилах төхөөрөмжийн хор, сэлбэгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хорооны гишүүдийг бүрэн оролцуулаагүй, оролцоогүй гишүүнийг сонгон тушаал шийдвэр гаргаж гишүүнийг шинээр томилоогүй; 6. Бүх төрлийн өргөх, зөөх механизмыг ашиглах тусгай эрх олгох сургалт, ажилчдын эрүүл мэндийн хугацаат үзлэгийн худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг, гэрээнд туслан гүйцэтгэгч авах болон түүнтэй холбоотой харилцаа, ажил үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлэх, гэрээний үнийн дүнгээс хэтэрсэн, дутуу гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэрхэн санхүүжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна.	1		1	-		
Үйлдвэрийн 2-р байрны барилгын их засварын 10.5 сая төгрөгийн ажлын тендертэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд: 1. Архивын баримт бичигт тендерийн сонгон шалгаруулалтын зарлалд тендер нээх эцсийн хугацааг 2024.03.28 гэснийг 2024.04.05 болгож, гараар зассан. 2. Өгөгдлийн хүснэгтэд нийт төсөвт өртгийг 296.4 сая төгрөгөөр буюу баталсан төсвөөс 36.9 сая төгрөгөөр зөрүүтэй, 41.1 сая төгрөгийн нэмэлт гэрээний 1.2 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг тооцоогүй, 0.1 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн, гүйцэтгэгч компани 1.3 сая төгрөгийн нэмэлт ажлын үнийн саналыг ирүүлээгүй. 3. Барилгын их засварын ажлын төсөвт тусгасан 10.4 сая төгрөгийн захиалагчийн албаны зардал болон магадалшгүй ажлын зардлыг тусад нь салгаж, ажлын гүйцэтгэлд тусгалгүй баталгаажуулсан, шууд зардлаар тооцсон, захиалагчийн хяналтын дүнг суутган тооцохгүйгээр санхүүжилтийг олгосон.	1	10482.8	1	10,482.8		
Бусад хууль тогтоомжийн дүн	8	14,352.9	2	10,482.8	6	3,870.1
Нийт дүн	9	14,352.9	2	10,482.8	7	3,870.1